

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Зүүнхараа Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: СЭА-2022/250-НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn
Сүхбаатар хот
2022 он

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа
Утас:70363040 Цахим хаяг:
enkhtuyach@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Батмөнх
Утас: 70363036 Цахим хаяг:
batmunkhb@audit.gov.mn
Гэрээгээр аудитыг гүйцэтгэсэн: Эн Ай Ти Эс аудит
ХХК
Захирал: Ш.Ичинхорлоо
Утас: 77270808: Цахим хаяг: nitsbalance@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын дүгнэлт.....	3-4
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5-6
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6-8
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9-11
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11-13
3. Аудитын тайлан	14
3.1 Ерөнхий зүйл	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	14-15
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	16
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	17-18
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	18
3.8 Аудитын гол асуудал.....	18
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18-19
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт.....	18-19
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	19
4. Аудитын илрүүлэлт.....	20
4.1 Залруулсан алдаа	20
4.2 Төлбөрийн акт.....	20
4.2 Албан шаардлага	21
4.3 Зөвлөмж.....	21-22
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХНХС	Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213200 Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум
Цагаан Эрэг II баг
Утас: 7036-3040, Факс: (976)-7036-3040
E-mail: Selenge@audit.gov.mn

᠒᠐᠒᠒.᠐2.᠒᠕ № СЭА-᠒᠐᠒᠒/᠒᠕᠐-᠒᠗-᠑᠒-᠓᠓
танай _____-ны № _____-т

СЭЛЭНГЭ АЙМГИЙН МАНДАЛ СУМЫН
ЗҮҮНХАРАА ПОЛИТЕХНИКИЙН КОЛЛЕЖИЙН
ЗАХИРАЛ Ц. ЭРДЭНЭЧУЛУУН ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Зүүнхараа Политехникийн коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Зүүнхараа Политехникийн коллежийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж, толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон			/төгрөгөөр/
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	271,266,723.13	244,813,516.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	0.00	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	9,823,674.13	5,100,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	261,443,049.00	239,713,516.00
35100	Түүхий эд материал	1,848,820.00	1,209,900.00
35130	Эм боох материал	1,848,820.00	1,209,900.00
35400	Хангамжийн материал	243,096,729.00	222,006,116.00
35420	Аж ахуйн материал	37,056,959.00	37,081,499.00
35430	Сэлбэг хэрэгсэл	109,023,589.00	108,837,889.00
35440	Түлш, шатах тослох материал	2,200,000.00	0.00
35450	Барилгын засварын материал	20,747,600.00	18,292,700.00
35460	Хүнсний материал	1,907,908.00	6,698,718.00
35470	Бусад хангамжийн материал	72,160,673.00	51,095,310.00
35600	Мал амьтад	16,497,500.00	16,497,500.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,761,270,729.76	2,677,029,377.72
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,761,270,729.76	2,677,029,377.72
39100	Газар	0.00	0.00
39200	Биет хөрөнгө	2,068,510,146.43	1,986,988,794.31
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,721,271,455.43	1,733,689,455.43
39202	Хуримтлагдсан элэгдэл	-162,519,592.41	-226,345,288.34
39203	Авто-тээврийн хэрэгсэл	438,785,363.00	438,785,363.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-341,584,626.72	-348,628,006.80
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	651,872,060.00	675,362,911.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-383,382,946.91	-413,912,544.92
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	137,004,911.00	137,004,911.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-100,009,920.44	-107,944,525.68
39214	Бусад үндсэн хөрөнгө	134,913,778.52	134,913,778.52
39215	Хуримтлагдсан элэгдэл	-44,513,050.04	-52,609,974.30
39217	Ном	16,672,715.00	16,672,715.00
39300	Биет бус хөрөнгө	692,760,583.33	690,040,583.41
39301	Программ хангамж	20,848,000.00	20,848,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-10,269,416.67	-12,989,416.59
39303	Бусад биет бус хөрөнгө	682,182,000.00	682,182,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,032,537,452.89	2,921,842,893.72
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,960,227.07	0.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,960,227.07	0.00
41300	Өглөг	3,960,227.07	0.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	3,960,227.07	0.00

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Зүүнхараа Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,028,577,225.82	2,921,842,893.72
51	Засгийн газрын хувь оролцоо	3,028,577,225.82	2,921,842,893.72
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,505,912,180.56	1,505,912,180.56
51200	Хуримтлагдсан үр дүн	373,326,021.16	266,591,689.06
51210	Өмнөх үеийн үр дүн	242,264,845.53	375,931,056.20
51220	Тайлант үеийн үр дүн	131,061,175.63	-109,339,367.14
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,149,339,024.10	1,149,339,024.10
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,032,537,452.89	2,921,842,893.72

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,629,077,348.80	1,367,678,971.40
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	289,980,248.80	50,431,271.40
120	Нийтлэг татварын бус орлого	289,980,248.80	50,431,271.40
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,394,328.80	2,658,220.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,980,728.80	1,638,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,413,600.00	1,020,220.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	265,098,000.00	33,613,051.40
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	19,487,920.00	14,160,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,339,097,100.00	1,317,247,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,332,802,100.00	1,317,247,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,332,802,100.00	1,317,247,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,295,000.00	0.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,498,016,173.17	1,462,858,338.54
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,498,016,173.17	1,462,858,338.54
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,409,105,268.69	1,408,194,684.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	838,447,878.06	850,280,299.96
210101	Үндсэн цалин	746,315,929.45	533,383,577.34
210102	Нэмэгдэл	39,385,016.10	222,424,472.74
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,746,932.51	28,719,673.65
210104	Урамшуулал	0.00	65,752,576.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,996,917.02	120,124,172.47
210201	Тэтгэврийн даатгал	74,170,994.99	85,810,719.06

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Зүүнхараа Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210202	Тэтгэмжийн даатгал	8,456,480.51	8,938,282.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,765,184.41	7,352,842.26
210204	Ажилгүйдлийн даатгал	1,691,296.10	1,412,127.60
210205	Эрүүл мэндийн даатгал	16,912,961.01	16,610,201.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	140,171,261.60	142,182,923.20
210301	Гэрэл, цахилгаан	23,204,792.80	12,742,631.09
210302	Түлш, халаалт	105,492,527.80	123,205,590.10
210303	Цэвэр, бохир ус	11,473,941.00	6,234,702.01
2104	Хангамж, бараа материалын зардал	33,340,494.80	33,218,410.42
210401	Бичиг хэрэг	3,633,802.80	2,223,900.00
210402	Тээвэр, шатахуун	5,406,397.80	4,969,425.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,730,514.20	7,206,774.92
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,912,900.00	6,338,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,656,880.00	12,480,310.00
2105	Нормативт зардал	28,159,984.00	31,042,940.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,742,720.00	2,094,720.00
210502	Хоол, хүнс	16,415,414.00	20,168,970.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	8,001,850.00	8,779,250.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	14,710,070.00	21,682,830.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	689,830.00
210604	Урсгал засвар	14,710,070.00	20,993,000.00
2107	Томилолт, зочны зардал	955,100.00	711,700.00
210702	Дотоод албан томилолт	955,100.00	711,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,078,608.00	28,038,783.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,600,000.00	21,600,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,680,000.00	1,700,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,600,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	728,590.00	1,431,283.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	253,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	306,000.00	1,695,000.00
210807	Газрын төлбөр	11,018.00	12,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	219,244,955.21	180,912,625.90
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	77,913,527.42	59,536,409.67
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	141,331,427.79	121,376,216.23
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,910,904.48	54,663,653.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,947,762.00	51,697,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,685,538.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,032,224.00	50,697,200.00

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Зүүнхараа Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,230,000.00	1,000,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,963,142.48	2,966,053.59
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,928,142.48	2,966,053.59
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	35,000.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	131,061,175.63	-95,179,367.14
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	14,160,000.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	0.00	14,160,000.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	131,061,175.63	-109,339,367.14

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,505,912,180.56	1,149,339,024.10	242,264,845.53	2,897,516,050.19
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,505,912,180.56	1,149,339,024.10	242,264,845.53	2,897,516,050.19
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	131,061,175.63	131,061,175.63
10	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,505,912,180.56	1,149,339,024.10	373,326,021.16	3,028,577,225.82
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,505,912,180.56	1,149,339,024.10	373,326,021.16	3,028,577,225.82
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	2,605,035.04	2,605,035.04
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,505,912,180.56	1,149,339,024.10	375,931,056.20	3,031,182,260.86
20	2021 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	1,505,912,180.56	1,149,339,024.10	266,591,689.06	2,921,842,893.72

4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,344,491,428.80	1,319,905,920.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,394,328.80	2,658,220.00
120	Нийтлэг татварын бус орлого	5,394,328.80	2,658,220.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	5,394,328.80	2,658,220.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,980,728.80	1,400,220.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,413,600.00	1,258,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,339,097,100.00	1,317,247,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	1,332,802,100.00	1,317,247,700.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1,332,802,100.00	1,317,247,700.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	6,295,000.00	0.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,341,863,031.60	1,317,610,120.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,341,863,031.60	1,317,610,120.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,252,952,127.12	1,262,946,466.41
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	845,648,050.70	855,380,299.96
210101	Үндсэн цалин	753,414,450.11	538,482,779.66
210102	Нэмэгдэл	39,486,668.08	222,425,270.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	4,495,756.89	28,719,673.65
210104	Урамшуулал	48,251,175.62	65,752,576.23
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	107,996,917.02	112,923,999.83
210201	Тэтгэврийн даатгал	96,124,347.66	78,610,546.42
210202	Тэтгэмжийн даатгал	2,740,483.91	8,938,282.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,602,172.31	7,069,985.48
210204	Ажилгүйдлийн даатгал	593,628.46	1,694,984.38
210205	Эрүүл мэндийн даатгал	5,936,284.68	16,610,201.42
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	142,371,261.60	139,982,923.20
210301	Гэрэл, цахилгаан	23,204,792.80	12,742,631.09
210302	Түлш, халаалт	107,692,527.80	121,005,590.10
210303	Цэвэр, бохир ус	11,473,941.00	6,234,702.01

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Зүүнхараа Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2104	Хангамж, бараа материалын зардал	32,690,407.00	26,597,100.42
210401	Бичиг хэрэг	3,431,602.80	2,223,900.00
210402	Тээвэр, шатахуун	5,193,010.00	4,969,425.50
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,730,514.20	7,206,774.92
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	5,912,900.00	6,338,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,422,380.00	5,859,000.00
2105	Нормативт зардал	22,415,820.00	39,325,280.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,474,120.00	1,455,800.00
210502	Хоол, хүнс	11,128,500.00	24,959,780.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	7,813,200.00	12,909,700.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,269,070.00	19,279,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,559,000.00	741,000.00
210604	Урсгал засвар	14,710,070.00	18,538,100.00
2107	Томилолт, зочны зардал	955,100.00	711,700.00
210702	Дотоод албан томилолт	955,100.00	711,700.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,078,608.00	30,436,783.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,600,000.00	21,600,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,680,000.00	1,700,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,500,000.00	1,600,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	728,590.00	1,431,283.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	253,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	306,000.00	4,093,000.00
210807	Газрын төлбөр	11,018.00	12,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,526,892.80	38,309,280.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	56,526,892.80	38,309,280.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	88,910,904.48	54,663,653.59
2132	Бусад урсгал шилжүүлэг	53,947,762.00	51,697,600.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21,685,538.00	0.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	31,032,224.00	50,697,200.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,230,000.00	1,000,400.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	34,963,142.48	2,966,053.59

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Зүүнхараа Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

213302	Хаагдсан данс	0.00	0.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	34,928,142.48	2,966,053.59
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	35,000.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	2,628,397.20	2,295,800.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	2,629,800.00	2,295,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,629,800.00	2,295,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	2,629,800.00	2,295,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	2,629,800.00	2,295,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-2,629,800.00	-2,295,800.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	-1,402.80	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,402.80	0.00

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,322,871,700.00	1,316,939,866.41	5,931,833.59	99.55
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,322,871,700.00	1,316,939,866.41	5,931,833.59	99.55
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,271,174,100.00	1,265,242,266.41	5,931,833.59	99.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	855,380,300.00	855,380,299.96	0.04	100.00
210101	Үндсэн цалин	548,234,300.00	538,482,779.66	9,751,520.34	98.22
210102	Нэмэгдэл	221,343,100.00	222,425,270.42	-1,082,170.42	100.49
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,848,000.00	28,719,673.65	6,128,326.35	82.41
210104	Урамшуулал	50,954,900.00	65,752,576.23	14,797,676.23	129.04
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,444,300.00	112,923,999.83	2,520,300.17	97.82
210201	Тэтгэврийн даатгал	81,357,100.00	78,610,546.42	2,746,553.58	96.62
210202	Тэтгэмжийн даатгал	8,521,800.00	8,938,282.13	-416,482.13	104.89
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,817,400.00	7,069,985.48	-252,585.48	103.71
210204	Ажилгүйдлийн даатгал	1,704,400.00	1,694,984.38	9,415.62	99.45

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Зүүнхараа Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210205	Эрүүл мэндийн даатгал	17,043,600.00	16,610,201.42	433,398.58	97.46
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	140,303,300.00	139,982,923.20	320,376.80	99.77
210301	Гэрэл, цахилгаан	13,939,000.00	12,742,631.09	1,196,368.91	91.42
210302	Түлш, халаалт	122,027,600.00	121,005,590.10	1,022,009.90	99.16
210303	Цэвэр, бохир ус	4,336,700.00	6,234,702.01	-1,898,002.01	143.77
2104	Хангамж, бараа материалын зардал	26,697,200.00	26,597,100.42	100,099.58	99.63
210401	Бичиг хэрэг	2,224,800.00	2,223,900.00	900.00	99.96
210402	Тээвэр, шатахуун	4,972,900.00	4,969,425.50	3,474.50	99.93
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	7,291,200.00	7,206,774.92	84,425.08	98.84
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	6,349,000.00	6,338,000.00	11,000.00	99.83
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,859,300.00	5,859,000.00	300.00	99.99
2105	Нормативт зардал	40,130,400.00	39,325,280.00	805,120.00	97.99
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,455,800.00	1,455,800.00	0.00	100.00
210502	Хоол, хүнс	25,764,000.00	24,959,780.00	804,220.00	96.88
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	12,910,600.00	12,909,700.00	900.00	99.99
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,608,100.00	20,606,900.00	1,200.00	99.99
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,070,000.00	2,068,800.00	1,200.00	99.94
210604	Урсгал засвар	18,538,100.00	18,538,100.00	0.00	100.00
2107	Томилолт, зочны зардал	764,100.00	711,700.00	52,400.00	93.14
210702	Дотоод албан томилолт	764,100.00	711,700.00	52,400.00	93.14
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,566,400.00	30,436,783.00	2,129,617.00	93.46
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21,600,000.00	21,600,000.00	0.00	100.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,000,000.00	1,700,000.00	300,000.00	85.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,600,000.00	1,600,000.00	0.00	100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,766,000.00	1,431,283.00	1,334,717.00	51.75
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	4,174,400.00	4,093,000.00	81,400.00	98.05
210807	Газрын төлбөр	426,000.00	12,500.00	413,500.00	2.93

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Зүүнхараа Политехникийн коллежийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	39,280,000.00	39,277,280.00	2,720.00	99.99
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	39,280,000.00	39,277,280.00	2,720.00	99.99
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	51,697,600.00	51,697,600.00	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	51,697,600.00	51,697,600.00	0.00	100.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	50,697,200.00	50,697,200.00	0.00	100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,400.00	1,000,400.00	0.00	100.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,322,871,700.00	1,316,939,866.41	5,931,833.59	99.55
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,317,247,700.00	1,314,281,646.41	2,966,053.59	99.77
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,317,247,700.00	1,314,281,646.41	2,966,053.59	99.77
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНАА С	5,624,000.00	2,658,220.00	2,965,780.00	47.27
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,124,000.00	1,400,220.00	1,723,780.00	44.82
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,500,000.00	1,258,000.00	1,242,000.00	50.32
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	123.00	123.00	0.00	100.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1.00	1.00	0.00	100.00
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	0.00	100.00
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	61.00	61.00	0.00	100.00
620001	Удирдах ажилтан	3.00	3.00	0.00	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	45.00	45.00	0.00	100.00
620003	Үйлчлэх ажилтан	13.00	13.00	0.00	100.00
65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	61.00	61.00	0.00	100.00

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Мандал сумын Зүүнхараа Политехник коллежийн/ цаашид *Зүүнхараа Политехникийн коллеж гэх*/ 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад төлбөрийн цахим баримт болон бараа материалын ангиллыг зөв бүртгэхтэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу аудитыг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-ийн аудитор Ц.Энхтуяа хариуцаж хэрэгжүүлэв. Аудитын чанарын анхан шатны хяналтыг “Эн Ай Ти Эс баланс Аудит ХХК-ийн менежер И.Туяа, захирал Ш.Ичинхорлоо, дараагийн шатны чанарын хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын аудитын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар гүйцэтгэв.

Зүүнхараа Политехникийн коллеж нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Эн Ай Ти Эс баланс Аудит” ХХК-д 2022 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Зүүнхараа Политехникийн коллеж нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Зах зээлийн эрэлтэд нийцсэн чадамжтай , мэргэжилтэй ажилтан бэлтгэх” гэж тодорхойлсон байна.

Зүүнхараа Политехникийн коллежийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Мэргэшлийн түвшний үндэсний тогтолцоог төлөвшүүлэх,
- Чадамжинд суурилсан сургалт, үнэлгээний тогтолцоог төлөвшүүлэх;
- Санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох,
- Чанарын баталгаажуулалт, байгууллагын менежмент засаглалыг сайжруулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг дараах хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”;
- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”.
- Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан тушаал 2021 оны 02 дугаар сарын 01-ны өдрийн дугаар А/35/А/10/9 тушаал,

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна дүгнэлээ.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дээд шатны төсвийн захирагч болох Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудит хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зүүнхараа Политехникийн коллеж нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

3.4 МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн, материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,498,016.2 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 14,980.2 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувь буюу 10,486.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Зүүнхараа Политехникийн коллежийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 84,241.3 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	9,823.6	5,100.0	(4,723.6)
Бараа материал	261,443.0	239,713.5	(21,729.5)
Бусад эргэлтийн хөрөнгө	-	-	-
Үндсэн хөрөнгө	2,761,270.7	2,677,029.3	(84,241.4)
Нийт хөрөнгө	3,032,537.4	2,921,842.9	(110,694.5)
Богино хугацаат өр төлбөр	3,960.2	-	(3,960.2)
Засгийн газрын оролцоо	3,028,577.2	2,921,842.9	(106,734.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,032,537.4	2,921,842.9	(110,694.5)

Авлага данс 5,100.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнагдсан нь цалингийн авлагын үлдэгдлээс шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 239,713.5 мянган төгрөг болж 21,729.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд хүнсний материал, аж ахуйн материал, хангамжийн материалын үлдэгдлээс зарцуулснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /анхны өртгөөр/ 3,839,459.1 мянган төгрөг болж өмнөх оноос 35,908.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 2,295.7 мянган төгрөгийн хагас автомат гагнуурын аппарат худалдан авч, Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар 33,613.1 мянган төгрөгийн худаг болон машин тоног төхөөрөмж /компьютер, олон үйлдэлт хувилагч машин/ үнэ төлбөргүй хүлээн авсантай холбоотой байна.

Тайлант онд НДШ-ийн 3,960.2 мянган төгрөгийн өр төлбөрийг барагдуулсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 2,921,842.9 мянган төгрөг болж 110,694.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалсан байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 1,367,678.9 мянган төгрөг болж өмнөх оноос 261,398.4 мянган төгрөгөөр буюу 16.1 хувиар буурсан байна. Энэ нь үнэ төлбөргүй хүлээн хөрөнгө буурсантай холбоотой болно.

Тайлант оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,462,858.3 мянган төгрөг болж өмнөх оноос 35,157.8 мянган төгрөгөөр буюу 2.3 хувиар буурсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Зүүнхараа Политехникийн коллежийн 2021 оны төсвийн төсөлд нийт зардал ба зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,354,777.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн нийт зардал болон зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг анх 1,354,777.6 мянган төгрөгөөр баталсан бол 12 дугаар сард 31,905.9 мянган төгрөгөөр бууруулан, **1,322,871.7** мянган төгрөгөөр эцэслэн баталсан байна.

Тайлант хугацаанд Зүүнхараа политехникийн коллежийн 2021 оны төсвийн хуваарьт дээд шатны байгууллагаас 3 удаа өөрчлөлт оруулсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр, 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,322,871.7 мянган төгрөгийн төсөв баталснаас 1,317,247.7 мянган төгрөгийг улсын төсвөөс, 5,624.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,317,247.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос 2,658.2 мянган төгрөг нийт 1,319,905.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд **1,316,939.9** мянган төгрөгийг зарцуулан, 2,966.0 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,316,939.9 мянган төгрөг буюу 99.5 хувьтай тайлагнагдсан байгаа нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 2,520.3 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 320.3 мянган төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 100.0 мянган төгрөгөөр, нормативт зардлыг 805.1 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардлыг 2,129.6 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус коллеж нь нэмэлт санхүүжилтийн дансаар орлого бүрдүүлээгүй байна.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

3.7.1 Үндсэн хөрөнгийн ангилалд ашиглаж байгаа боловч үлдэх өртөг нь “0” үлдэгдэлтэй болсон 735,775.9 мянган төгрөгийн анхны өртөгтэй, 145 нэр төрлийн хөрөнгүүдийг ашиглаж байгаа нь УСНББОУС-17 “Үндсэн хөрөнгө”-ийн 49 дэх “... дахин үнэлэгдсэн хөрөнгийн бодит үнэ цэнэ нь дансны үнээсээ материаллаг ялгаатай байвал цаашид дахин үнэлэх зайлшгүй шаардлагатай” гэсэн заалттай нийцэхгүй байна. Иймд “0” үлдэгдэлтэй хөрөнгийг цаашид ашиглах бол дахин үнэлэх эсвэл акталж устгах асуудлыг эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

3.7.2 Тайлант онд ХНХС-ын тушаалаар ур чадварын нэмэгдлийг шинэчлэн тогтоож өгөөгүйгээс тус коллежийн захирал Ц.Эрдэнэчулуунд ХНХС-ын 2020 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн А/122 дугаар тушаалаар тогтоосон 25 хувиар тооцон 2,987.5 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдлийг олгосон нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт “Төрийн үйлчилгээний албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох нийтлэг журам” -тай нийцэхгүй байна.

Цаашид төсвийн ерөнхийлөн захирагчийн зүгээс төсвийн шууд захирагчид олгох ур чадварын нэмэгдлийг тогтоосон хугацаанд нь шинэчлэн тогтоож байх шаардлагатай байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны цахим хуудсанд оруулбал зохих 149 мэдээллээс 120 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, 28 мэдээллийг хугацаа хоцроон, 1 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

3.9.2 Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Зүүнхараа Политехникийн коллежийн тайлант оны үйл ажиллагаанд 1,322,871.7 мянган төгрөгийн төсөв батлагдаж, гүйцэтгэлээр 1,316,939.9 мянган төгрөгийг зарцуулан, төсвийн төлөвлөгөөг 0.5 хувиар хэмнэсэн нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1-д: “.....*батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аа с доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах*” гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 14,724.1 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоосныг бүрэн барагдуулж, 2 зөрчилд зөвлөмж өгөгдсөнөөс шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаанд нь байршуулж байх зөвлөмжийг биелүүлээгүй байна.

Хүснэгт 2. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Хэрэгжилтийн хувь
	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Төлбөрийн акт	2	14,724.1	2	14,724.1	100
Зөвлөмж	2		1		50.0
Нийт дүн	4	14,724.1	3	14,724.1	75.0

Өмнөх аудитаар өгсөн холбогдох мэдээллийг шилэн дансны цахим хуудаст тогтоосон хугацаанд мэдээлж байх зөвлөмжийг хэрэгжүүлэлгүйгээр тайлант онд давтан гаргасан тул МУЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1 дэх “Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана”, 4.2.1.10: “*Аудитаар илэрсэн алдаа, зөрчил түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол*” гэсэн заалтын дагуу албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

1. Тайлант онд улс орныг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаагаас шалтгаалан байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэх, хөрөнгийн биет тооллого хийх гэх мэт хөрөнгийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

2. Тайлант онд төлбөрийн баримтын цахим системд шивэгдсэн бараа материалын худалдан авалтад тус байгууллагад хамааралгүй 5,923.4 мянган төгрөгийн худалдан авалт илүү шивэгдсэн байгаа нь анхан шатны баримтгүй болон баримтын бүрдэлгүй орлого зарлагын гүйлгээг хүлээн зөвшөөрч данс бүртгэлд тусгах эрсдэлийг үүсгэж байна. Иймд төлбөрийн баримтын цахим системийг үнэн зөв хөтлөх, алдаатай эсвэл буруу шивэгдсэн баримтуудыг тухай бүр залруулж байх шаардлагатай байна.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 78,779.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 24,362.2 мянган төгрөгийн 5 алдааг аудитын явцад залруулж, 1,034.9 мянган төгрөгийн 2 зөрчилд 1 төлбөрийн акт, 2,180.0 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 51,202.6 төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өглөө.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нийт 24,362.2 мянган төгрөгийн санхүүгийн тайлагнал, бүртгэлтэй холбоотой дараах алдааг залруулж, баталгаажууллаа. Үүнд:

- Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь цалингийн зардлын дүнг мөнгөн гүйлгээний тайлан дахь цалингийн зардлын дүнгээс 2,101.0 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн,
- Санхүүгийн байдлын тайлан дахь цалингийн авлагын дүн 5,100.0 мянган төгрөгийг цалингийн урьдчилгаа гэж буруу илэрхийлсэн,
- Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь цалингийн зардлын дүнг авлагын дэлгэрэнгүй тайлан дахь дүнгээс 2,999.8 мянган төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн,
- Санхүүгийн үр дүнгийн тайлан дахь 14,160.0 мянган төгрөгийн үйл ажиллагааны бус зардлыг үйл ажиллагааны зардлаар бүртгэж, тайлагнасан,
- Урьд оны үлдэгдлээс санхүүжих орлогын дүнг санхүүгийн үр дүнгийн тайланд 1.4 мянган төгрөгөөр дутуу илэрхийлснийг тус тус залруулав.

4.2 Төлбөрийн акт

1.Эрх бүхий албан тушаалтны тушаал шийдвэргүйгээр захирал Ц. Эрдэнэчулуунд үр дүнгийн урамшуулал 896.2 мянган төгрөгийг олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.7 дахь “*Энэ журмын 4.3-т заасан нөхцөлийг хангасан багш, албан хаагчид улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг тухайн сургалтын байгууллагын эрхлэгч, захирал гаргана. Сургалтын байгууллагын эрхлэгч, захиралд улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшуулал олгох шийдвэрийг томилсон эрх бүхий албан тушаалтан гаргана.*” гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд “*Нийцсэн бөгөөд зохистой байх*” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тушаал шийдвэргүйгээр олгосон улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

2. Багш Б.Эрдэнэ-Өлзийд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг 15 хувиар буюу тогтоосон хувь хэмжээнээс хэтрүүлэн 138.7 мянган төгрөгөөр илүү олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно*”, Захирлын 2021 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн

Б/63 дугаар тушаал “Багш Б.Эрдэнэ-Өлзий-10%” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн ба “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү тооцож олгосон цалинг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоох.

4.3 Албан шаардлага

1. Дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрөлгүйгээр буюу төсөвт зохицуулалт хийлгэлгүйгээр гэрэл цахилгааны зардлаас тоног төхөөрөмж худалдан авахад / аянга зайлуулагч/ 2,180.0 мянган төгрөгийг гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно", Сангийн сайдын 2018 оны 134 дүгээр тушаалаар баталсан Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх журмын 3.1.6 дахь "... дээд шатны төсвийн захирагчийн зөвшөөрлийг албан бичгээр авсан байх" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх", "Ангилал" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, шаардлагатай тохиолдолд зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулахдаа холбогдох албан тушаалтнаас зөвшөөрөл авч, төсөвт зохицуулалт хийлгэх албан шаардлага хүргүүлэх.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав.

1. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлтэй холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Төсвийн төлөвлөлтийг бодит судалгаа, мэдээлэл дээр үндэслэн зардлын зүйл, эдийн засгийн ангиллаар нь үнэн зөв төлөвлөөгүйгээс шаардлагатай цэвэрлэгээний материал худалдан авахад нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 8,418.7 мянган төгрөгийг , мэдээлэл технологийн үйлчилгээ зардлаас интернэтийн төлбөрт 650.0 мянган төгрөгийг санхүүжүүлсэн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад дараах зарчмыг баримтална", 5.1.2 дахь "Төсвийн иж бүрэн, **үнэн зөв** байдлыг хангасан байх" гэсэн заалтыг зөрчсөн бөгөөд санхүүгийн тайлангийн "Нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул зардлыг бодит тооцоо судалгаан дээр үндэслэж, үнэн зөв төлөвлөж, хэрэгжүүлэх.

2. Бараа, ажил, үйлчилгээний төлбөр тооцооны баримтууд

2.1 Илрүүлэлт: Тайлант онд 11,529.9 мянган төгрөгийн бараа материалын худалдан авалтыг холбогдох үзүүлэлтүүдийг тусгасан төлбөрийн баримтаар баталгаажуулаагүй, цахим системд шивэгдээгүй байна.

2.2 Өгсөн зөвлөмж: Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйл 28.5-д “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэсэн заалт болон Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал 1 дүгээр хавсралтын 6.5 дахь “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 “Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага”-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ” гэж заасны дагуу төлбөрийн цахим баримтыг үндэслэж ажил гүйлгээг гүйцэтгэж байх.

3. Бараа материалын тайлантай холбоотой асуудал:

3.1 Илрүүлэлт: Бараа материалын тодруулга тайланд 19,296.2 мянган төгрөгийн орлогын, 11,307.8 мянган төгрөгийн зарлагын ажил гүйлгээг буруу ангилж, бүртгэсэн байна

3.2 Өгсөн зөвлөмж: Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 “үнэн зөв байх”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн заавар”-тай нийцээгүй бөгөөд “Ангилал” батламж мэдэгдлийг хангахгүй байгаа тул бараа материалын ажил гүйлгээг зөв ангилж бүртгэж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 06 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Зүүнхараа политехникийн коллеж	11	78,779.7	5	24,362.2	2	1,034.9	1	2,180.0	3	51,202.6